



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2007 оны 06 сарын 20


дугаар 224

Гадаадад суралцуулах тухай


Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 52 дугаар тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам", Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын даргын 2007 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн ХЭГ/757 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Халзан овогтой Батжаргалыг 2007-2008 оны хичээлийн жилээс АНУ-ын Хойд Вирджинийн их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын захиалгын дагуу 2 жилийн хугацаагаар Сургалтын төрийн сангийн эзэлээр суралцуулсугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.



САЙД


Ө.ЭНХТҮВШИН